



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХ-ЫН ШИЙДВЭР ӨР ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

2006 оны 5 дугаар сарын 11-ны өдөр Дархан

Дугаар 36

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3,6, 12 дугаар зүйлийн 1-ийн 15, 20 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Тус аймгийн нутаг дэвсгэрт цахилгаан, цэвэр бохир ус, дулааны эрчим хүч хэрэглэдэг барилга байгууламжийг иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагууд өөр хоорондоо худалдан авах, өгөхдөө өр төлбөргүй нөхцөлд үр хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгэж, хөдөлгөөн хийж гэрчилгээ олгож байхыг Газрын алба /З.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

2.Өр төлбөргүй болохыг баталсан албан тодорхойлолтыг шаардлагатай аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгож ажиллахыг “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК, “Дархан Дулааны Сүлжээ” ХК, “Дархан-Ус суваг” ХК /Ч.Энхболд, С.Дэлгэр, С.Элбэгбаян/-д тус тус даалгасугай.

ДАРГА Л.ГҮНЧИН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ